

ЗАСГИЙН ГАЗРЫН 2012 ОНЫ 2 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Санхүү, төсвийн талаар

Зээлийн хэлэлцээрийн төслийн тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын хооронд байгуулах “Нийгмийн салбарыг дэмжих хөтөлбөрийн хоёр дахь шатны Зээлийн хэлэлцээр”-ийн төслийг зарчмын хувьд дэмжиж, төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр тогтов.

Төсвийн тодотголын тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, тэдгээртэй холбогдуулан Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн болон Улсын Их Хурлын 2011 оны 54, 55 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслийг хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 161-д заасны дагуу Улсын Их Хуралдааны чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.

Автобензин, дизелийн түлш, хүнсний зарим бараа, нийтийн тээврийн үнийг тогтворжуулах хөтөлбөрийг зохион байгуулах, хяналт тавих зөвлөлийн ажлын явцын талаарх мэдээллийг Зөвлөлийн дарга, Сангийн сайд Засгийн газрын хуралдааны үеэр Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Улсын Их Хурлын 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Тогтвортой амьжиргаа-2 төсөл”-ийн нэмэлт санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай, Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангаас 2011-2015 онд авах зээлийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай, Баруун бүсийн тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай хуулиудыг батлуулсан.

Үнэт цаас болон Засгийн газрын баталгаа гаргах тухай Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, иргэдийг жилийн 6 хувийн хүүтэй орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулахад шаардагдах хөрөнгийг бүрдүүлэхийн тулд Хөгжлийн банкны 200 хүртэл тэрбум төгрөгийн үнэт цаас гаргахаар шийдвэрлэж, үнэт цаасны үндсэн ба хүүгийн төлбөрт Засгийн газрын баталгаа гаргахыг Сангийн сайдад зөвшөөрөв.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2012 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр 325.8 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 12.2 тэрбум төгрөгөөр буюу 3.9 хувиар давж, улмаар 2011 оны мөн үеийнхээс 109.5 тэрбум төгрөгөөр буюу 50.6 хувиар өссөн.

Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага 2012 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр 529.2 тэрбум төгрөг (үүнээс: улсын төсвийн зарлага 392.9 тэрбум төгрөг) зарцуулахаас гүйцэтгэлээр 260.0 тэрбум төгрөг (улсын төсвийн зарлага 170.2 тэрбум төгрөг)-т хүрч, төлөвлөсөн нэгдсэн төсвийн зарлагын 49.1 хувийг (улсын төсвийн зарлагын 43.3 хувийг) санхүүжүүлсэн гүйцэтгэлтэй гарлаа.

Хүний хөгжил санд 2012 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр (өссөн дүнгээр) нийт орлого 51.1 тэрбум төгрөг төвлөрч, төлөвлөгөө 268.6 хувиар буюу 37.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2012 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 67.2 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 65.8 тэрбум төгрөгийн ашигтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 33.8 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 43.5 тэрбум төгрөгийн ашигтай) гарсан.

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 39 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 2012-2013 онд баримтлах чиглэл”-ийг баталж, энэхүү чиглэлийг 2012 оны 2 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж хэрэгжилтийг ханган ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгов.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 41 дүгээр тушаалаар Эмийн бүртгэлийн журам, Биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн журам, Эм, оношлуур, биологийн идэвхт бүтээгдэхүүн бүртгүүлэх өргөдлийн маягт, Бүртгэлийн гэрчилгээний загвар, Бүртгэлийн шинжээч ажиллуулах журам, Бүртгэлийн хураамж, түүнийг зарцуулах журам, Бүртгэлийн шинжээчийн ашиг сонирхлын зөрчлийн мэдүүлгийн загварыг тус тус баталлаа.

Эрүүл мэндийн сайдын 2012 оны 63 дугаар тушаалаар Гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээний удирдамж, Нөхөн үржихүйн эм хэрэгслийн хангамжийн тогтвортой байдлыг хангах журам, Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэгдэж байгаа нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм хэрэгслийг нийгмийн эмзэг давхаргын иргэдэд үнэ төлбөргүй олгох журмыг тус тус батлав.

Нийгмийн хамгааллын талаар

“Өрхийн хөгжлийг дэмжих жил”-ийн ажлын нээлтийг Төрийн ордонд зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд 2012 оныг бага орлоготой иргэдийнхээ амьжиргааг дундаж хэмжээнд хүргэх, бизнес эрхлэгчдийг дэмжихэд онцгой анхаарах, идэвх санаачлагатай ажиллаж байгаа өрхийг урамшуулах, эдийн засгийн өсөлтийн үр шимийг шууд хүртэж чадахгүй байгаа өрхийг өөрсдийнх нь оролцоо, санаачлага дээр тулгуурлан боловсрол, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээгээр дэмжин хөгжүүлэхэд гол ажлуудыг чиглүүлнэ.

УИХ-ын зарим гишүүдийн өргөн барьсан Нийгмийн даатгалын тухай хуулиудыг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэв.

Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын болон халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулав.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны чиглэлээр

Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол. 2012-2013 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 12 жилийн сургалтад шинээр хэрэглэх 5, 10 дугаар ангийн сурах бичгийн эх бэлтгэх дотоодын нээлттэй тендер шалгаруулалтын хуваарь ёсоор 2 дугаар сарын 8-ны өдөр нээж, үнэлэх ажлыг зохион байгуулсны гадна 2012-2013 оны хичээлийн жилд хэрэглэх багшийн журналыг хэвлэх, түгээх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах дотоодын нээлттэй тендер шалгаруулалтын зарыг “Өнөөдөр”, “Үндэсний шуудан”, “Зууны мэдээ” сонин болон e.procurement веб сайтад байрлуулан, зарын дагуу хүсэлт гаргасан хэвлэлийн газруудад тендерийн баримт бичгийг түгээлээ.

Бага, дунд боловсролын шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг турших сургалт зохион байгуулах сургагч багш нарыг бэлтгэх 2 дахь шатны 3 хоногийн семинарыг Кембрижийн олон улсын шалгалтын төвтэй хамтран зохион байгуулсны дээр 3 дахь шатны 5 хоногийн семинарын бэлтгэл ажлыг хангах, сургалтын материал боловсруулах, орчуулах, хэвлэх ажлыг зохион байгуулав.

Монголын багш нарын баярын 46 дахь өдрийн ёслол хүндэтгэлийн нэгдсэн арга хэмжээг энэ оны 2 дугаар сарын 3-нд тэмдэглэн өнгөрүүлээ.

Дээд болон мэргэжлийн боловсрол. “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын, “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу оюутанд үндэсний тэтгэлэг олгох ажлыг зохион байгуулж, 2012 оны 1 дүгээр сарын тэтгэлэгийг суралцагчдад 100 хувь олголоо.

Финляндын Засгийн газраас 2012 онд анх удаа манай улсад 3-9 хугацаатай докторын түвшний судалгааны тэтгэлэгт 10 хүнийг нэр дэвшүүлэх эрх олгосны дагуу тэтгэлгийн тухай мэдээллийг төрийн өмчийн их сургуулиуд болон ШУА-д хүргүүлж, эдгээр байгууллагаас нэр дэвшүүлсэн 8 хүний тэтгэлэгт хамрагдах өргөдөл болон холбогдох бичиг баримтыг Финляндын талд хүргүүлэв.

“Бизнесийн сургууль, хөтөлбөрүүдийн магадлан итгэмжлэл” сэдэвт олон улсын сургалт семинарыг АНУ-ын магадлан итгэмжлэлийн байгууллага, Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлтэй хамтран 2012 оны 2 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулав.

Монгол Улсын Боловсролын их сургуулийн Гадаад хэлний сургуулийн хичээлийн шинэ байрыг ашиглалтад хүлээлгэн өглөө.

Соёл, урлаг. Хүннү гүрэн байгуулагдсаны 2221 жилийн ой, Монгол үндэстний уламжлалт сар шинийн баярт зориулж Монголын болон БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-ын Тува улсын уран бүтээлчдийг оролцуулсан “Уяхан замбуу тивийн нар” концерт бэлтгэж, олон нийтэд зориулан 2012 оны 2 дугаар сарын 16-ны өдөр Соёлын төв өргөөнд тоглож, мөн сарын 21-ний орой МҮОНТВ-ээр орон даяар үзүүллээ.

Засгийн газрын 2008 оны 195 дугаар тогтоолоор баталсан “Оны шилдэг уран бүтээлч шалгаруулах журам”-ыг үндэслэн БСШУ-ы сайдын 2012 оны 80 дугаар тушаалаар байгуулсан зөвлөлийн хурлын дүгнэлтийг үндэслэн 2011 оны тайз, дэлгэцийн шилдэг найруулагч, зураач, жүжигчин, дуучин, хөгжимчин, бүжигчинг шалгарууллаа.

АНУ-ын Хойд Каролина хотын Байгалийн шинжлэх ухааны музейд гарсан “Чингис хааны Монгол-Их Эзэнт гүрний амьдрал” сэдэвт үзэсгэлэнгийн монголын талын үзмэрүүдийг АНУ-ын Чикаго хотын Байгалийн түүхийн Фиельд музейд хүлээлгэн өгч, уг үзэсгэлэнгийн нээлтэд БСШУЯ-ны төлөөлөгчдийг оролцуулав.

Богд хааны ордон музейд хадгалагдаж байсан Бурхан багшийн шүдийг Түүх, соёлын хосгүй үнэт дургсалт зүйлийн жагсаалтад нэмж оруулах Засгийн газрын шийдвэрийн төсөл, Ерөнхий сайдын захирамжийн төслийг боловсруулан Засгийн газрын 2012 оны 2 дугаар сарын 29-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэв.

Шинжлэх ухаан, технологи. Инновацийн тухай хуулийн төслийг УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх ухааны байнгын хорооны хурлаар хэлэлцүүлж, УИХ-ын хаврын чуулганаар батлуулахад бэлэн болгосны зэрэгцээ эрдэм шинжилгээний ажилтанд олгох зэрэг дэвийн нэмэгдлийн хэмжээ тогтоох асуудлыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэлээ.

“Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг” MNS 5217: 2011 стандартыг Стандартчиллын Үндэсний Зөвлөлийн 2012 оны 2 сарын 16 өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулав.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр

Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх хөдөө аж ахуйн болон ойн техник, тоног төхөөрөмжийн жагсаалтыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлав.

Махны хангамжийг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батласан.

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөнөөс гаргасан Завлэмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж баталлаа.

Нөөцийн махны өргөтгөсөн худалдааг Тэнгэр бөөний төв, Цамбагарав худалдааны төвд зохион байгуулж нийт 277.955 тн мах, Мишээл экспо үзэсгэлэнгийн гадна 9 компани 11 автомашинаар жижиглэн болон гулуузаар хонь, ямаа, үхрийн нийт 70 орчим тонн мах нийслэлийн хэрэглэгчдэд борлуулав.

2012 оны төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төвлөрсөн арга хэмжээний болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлах тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2011 оны А/255 тоот тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын төсөвт хөнгөн үйлдвэрлэл эрхлэгчдэд олгохоор тусгагдсан зээлийг бодлогоор дэмжин, санхүүжүүлэх шаардлагатай стратегийн ач холбогдолтой, төслүүдийн жагсаалтыг гаргав.

Зам, тээвэр, барилга хот байгуулалтын чиглэлээр

“Зарим хотуудад улсын зэрэглэл тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төслийг Төрийн байгуулалтын байнгын хорооны 2012 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж, УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийслэл хоттой холбогдоогүй байгаа зургаан аймгийн төвийн авто замын ажлыг эхлүүлэх асуудлыг Засгийн газрын 2012 оны 2 дугаар сарын хуралдаанаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргав.

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг Зохицуулах Зөвлөл байгуулж, дүрмийг батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг 2 дугаар сарын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн батлав.

100 мянган айлын орон сууцны хэрэгжилтийн талаар танилцуулга, тэмдэглэлийн төсөл бэлтгэж, Засгийн газрын 2 дугаар сарын хуралдаанд танилцуулан тэмдэглэл гарсан.

Засгийн газрын 2012 оны 2 дугаар сарын хуралдаанаар иргэдэд орон сууцны 6 хувийн хүүтэй зээл олгох, үнэт цаас болон Засгийн газрын баталгаа гаргах тухай асуудлыг хэлэлцээд иргэддээ илүү боломж олгох үүднээс орон сууцны талбайн хэмжээг 55 метр квадрат хүртэл нэмэгдүүлэхээр шийдвэрлэв.

Эрдэс баялаг, эрчим хүчний салбарын чиглэлээр

Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын “Ашигт малтмал, аж үйлдвэр болон технологийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн хүрээнд Засгийн газрын Ажлын хэсэг байгуулах тухай Ерөнхий сайдын захирамжийн төсөл, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлав.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 13 тоот захирамжаар “Ашигт малтмал, аж үйлдвэрийн болон технологийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангуулах Засгийн газрын Ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулав.

Эрчим хүчний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийн төслийг Засгийн газрын 2 дугаар сарын хуралдаанд хэлэлцэн шийдвэрлэсэн.

Улаанбаатар хотын агаарын бохирлыг бууруулах чиглэлээр төвлөрсөн дулаан хангамжийн талаар хэрэгжүүлсэн ажил, цаашид төлөвлөгдөж буй ажлуудын талаар танилцуулга мэдээлэл бэлтгэн Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үндсэний хорооны ажлын албанд хүргүүлэв.

Эрчим хүчний барилга угсралтын компани, аж ахуйн нэгжид “Тусгай зөвшөөрөл шинээр олгох, тусгай зөвшөөрөл сунгах, категори өөрчилж нэмэлт ажилбарын зөвшөөрөл олгох тухай” Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2012 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 36 тоот тушаал гарлаа.

Нүүрсний экспортын жишиг үнийн талаар санал солилцох уулзалтыг ЭБЭХЯ, “Нүүрс ассоциаци”, нүүрс экспортлогч аж ахуйн нэгж, байгуулагуудыг оролцуулан зохион байгуулав.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

Засгийн газрын 2012 оны 7 дугаар тогтоолоор "Ховор амьтны жагсаалт"-ыг баталж, "Ховор амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журам"-ыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар батлан мөрдүүлж байна.

Иргэн аж ахуйн нэгж байгуулагуудаас байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэхээр ирүүлсэн 25 төслийн материалыг судалж шаардлага хангасан 12 аж ахуйн нэгж байгуулагад ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргаж, нарийвчилсан үнэлгээний 6 тайланг хэлэлцэн шийдвэрлэж, үнэлгээний эрх бүхий 98 мэргэжлийн байгуулагад аттестатчлал явуулав.

Биотехнологийн шинжлэх ухааны ололтыг байгаль хамгаалах үйлсэд өргөнөөр ашиглах боломжит аргууд сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг ХАА-н их сургуультай хамтран зохион байгуулав.

Хууль зүйн чиглэлээр

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл ахуйн тухай зэрэг хуулийн төсөлд санал өгч хуулийн төслийн үзэл баримтлалыг хянан буцаан хүргүүлсэн.

УИХ-ын гишүүн Д.Загджавын санаачилсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатарын санаачилсан Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, УИХ-ын гишүүн Р.Будын санаачилсан Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, УИХ-ын гишүүн Л.Гүндалайн санаачилсан Хүүхдийн мөнгө олгох тухай, УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцангын санаачилсан Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, УИХ-ын гишүүн З.Энхболдын санаачилсан Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, УИХ-ын гишүүн Р.Будын санаачилсан Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, НӨАТ-аас чөлөөлөх тухай зэрэг хуулийн төсөлүүдэд Засгийн газраас өгөх санал дүгнэлтийн төсөл бэлтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн.

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгосон.

УИХ-ын гишүүн Я.Батсуурийн санаачилсан "Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай" УИХ-ын тогтоолын төслийн хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд Засгийн газраас өгөх санал дүгнэлтийн төсөл бэлтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн.

Засгийн газрын 2011 оны 338 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын иргэний үнэмлэхийн тодорхойлолт, дүрэм болон 2011 оны 329 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын иргэний үнэмлэхийн загвар, нууцлалд өөрчлөлт оруулах асуудлаар Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж 2012 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 33, 34 дүгээр тогтоолоор батлав.

Батлан хамгаалах салбарт

АНУ-ын БХЯ-тай хамтран “Батлан хамгаалах байгууллыг шинэчлэх санаачлага” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа “Нөөцийн удирдлага, зохицуулалт”, “Цэргийн мэргэжлийн боловсрол” сэдэвт 9 дэх удаагийн хамтарсан семинарыг зохион байгууллаа.

Монгол, Оросын Зэвсэгт хүчнүүдийн хамтарсан “Сэлэнгэ” сургалт, дадлагын төлөвлөлтийн хурлыг зохион байгуулав.

НҮБ-ын болон Олон Улсын ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн багуудад 437 /Афганистан-369, Судан-Дарфур-68/, НҮБ цэргийн ажиглагч болон штабын офицероор 15, /MONUSCO-2, MINURSO-4, UNMISS-2 UNMISS-SO-5, UNAMID-2/, АНУ-ын төвийн командлалд суугаа холбогчдын багт 3, НҮБ-ын дэргэд суугаа байнгын төлөөлөгчийн газрын дэргэдэх цэргийн зөвлөх 1, Монгол Улсын Зэвсэгт хүчнээс гадаадад нийт 456 Цэргийн албан хаагч үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багуудын мэдээг нэгтгэн боловсруулж Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлээд байна.

“Khaan Quest 2012” олон улсын хээрийн сургуульд цэргийн алба хаагчдаа оролцуулах урилгыг Батлан хамгаалах ямаар дамжуулан 15 улсад хүргүүлсэн.

ЦДБЭЧ-тай хамтран 6 дахь жилдээ уламжлал болгон зохион байгуулсан “Цагаан сар Монгол Түмний уламжлалт их баяр” уралдаант тэмцээнд Улаанбаатар цэргийн хүрээний 14 ангиас шалгарсан багууд оролцов.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР